

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
5 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх “Гэрэл” хэсэгчилсэн арга хэмжээг тээврийн цагдаагийн тасагтай хамтран зохион байгуулж, жолооч нарт шөнийн цагаар автомашины гэрэлтүүлгийг зөв хэрэглэх, гэрэл шилжүүлж байх талаар заавар зөвлөмж өгч, гэрлийн тусгал бууруулагчийг жолооны буруу хүрдтэй авто машинуудад үнэгүй суурилуулах болон 16 сумын цагдаагийн тасаг, хэсгүүдийг интернетийн шилэн кабельд холбох арга хэмжээг зохион байгуулсан.

Цагаатгалын хуулийн дагуу шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэн 2020 оны эхний 5 сарын байдлаар 6 иргэнд 240 сая төгрөгийн нөхөх олговор олгож, орон нутгийн телевизээр явцыг нэвтрүүлэн, ЦАУЗБУК-т тайланг хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн Онцгой комисс 5-р сарын 04-ний өдөр хуралдаж, энэхүү хуралдаанаас “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” аймгийн Засаг даргын 2020 оны А/280 дугаар захирамжийг гаргасан байна.

Дэлхий дахинд ковид-19 цар тахлын халдвар нэмэгдэж, Засгийн газрын тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг сунгасантай холбогдуулан захирамжаар аймгийн хэмжээнд олон нийтийг хамарсан арга хэмжээ, спорт, урлагийн уралдаан тэмцээн, хурал зөвлөгөөн, интернет тоглоом, баар, караоке, хурдан морины уралдаан, сүм хийдийн үйл ажиллагааг хориглосныг 2020 оны 5 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хугацаанд сунгахаар шийдвэрлэсэн байна.

Мөн энэ хугацаанд аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх цагийн хуваарийг 10:00-17:00 цаг, аймгийн Биеийн тамир, спортын газрын спорт заалны ажиллах хуваарийг халдвар хамгааллын дэглэмийн дагуу 09:00-20:00 цаг гэж тогтоосон байна.

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 33 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн А/266 дугаар тушаалын дагуу “Ковид-19 халдварт цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт ширээний дадлага сургуулилтыг аймгийн Онцгой комиссоос 2020 оны 5-р сарын 6-наас 8-ны өдрүүдэд зохион байгуулж, дадлага сургуулилтанд аймгийн штабын бие бүрэлдэхүүн оролцож, Улсын Онцгой комиссын шуурхай штабаас өгсөн цагийн байдал дээр шуурхай ажиллаж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон бусад холбогдох баримт бичгүүдийг боловсруулан, мэдээллийг аймгийн Онцгой комиссын шуурхай штабд мэдээллэн, эрүүл мэндийн байгууллагуудаас цаг тутам коронавируст халдварын үеийн бэлэн байдалд ажилласан мэдээг авч, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.

Аймгийн Сонгуулийн хорооноос 5-р сарын 20, 21-ний өдрүүдэд сумдын сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт 2020 оны УИХ-ын сонгуулийг хэрхэн зохион байгуулж явуулах талаар чиглэл өгөх сургалтыг зохион байгуулсан байна.

“Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолоор иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг аймаг, сумдад байгуулахаар шийдвэрлэсний дагуу Архангай аймагт “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг байгуулах, үйлчилгээ үзүүлэх ажилтнуудад зориулсан танилцуулга сургалтыг 5-р сарын 12-ны өдөр зохион байгууллаа.

Танилцуулга, сургалтын үеэр аймаг, сумын “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д ашиглагдах нэг суманд 5.0 сая, аймгийн хэмжээнд нийт 100.0 орчим сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг хүлээлгэж өглөө.

5-р сарын 21-ний өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатаар ахлуулсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Экологийн

цагдаагийн албаны ажлын хэсэг, аймгийн ЗДТГ-ын дарга Б.Цэрэннадмидаар ахлуулсан орон нутгийн ажлын хэсэгтэй хамтран Цэнхэр сумын Орхон багт хийгдсэн нөхөн сэргээлтийн ажлын нөхцөл байдалтай газар дээр нь танилцлаа.

Энэ үеэр Цэнхэр сумын Орхон багт ажиллаж буй байнгын постод Цагдаагийн ерөнхий газрын харьяа Экологийн цагдаагийн албанаас хүч нэмэгдүүлэн ажиллуулах, нөхөн сэргээлтийг үргэлжлүүлэн мэргэжлийн байгууллагаар хийлгэх шийдвэрүүдийг тус тус гаргасан байна.

Монгол Улсын Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газраас сумын Мал эмнэлгийн тасгийг бэхжүүлэх ажлын хүрээнд 19 сумын Мал эмнэлгийн тасгийн дарга, тархвар зүйч нарт ган төмөр рам, хигээс бүхий төмөр обуд, салхины шил, иж бүрэн хамгаалалт /малгай, арьсан болон нэхий бээлий/, дохиолол болон байршил тогтоох төхөөрөмж зэргийг суурилуулсан тусгай зориулалтын мотоцикл болон оффисийн иж бүрэн тавилга, суурин компьютер, принтер олгосныг 5-р сарын 27-ны өдөр аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасан, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга П.Гомбодорж, Мал эмнэлгийн газрын дарга А.Саруулжаргал нар гардуулан өгсөн байна.

Мөн энэ үеэр аймгийн Мал эмнэлгийн газарт 2019 оны ЛАДА маркийн автомашиныг гардуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Булган, Ихтамир, Өндөр-Улаан, Цахир, Тариат, Хангай, Чулуут, Жаргалант, Эрдэнэбулган, Цэнхэр, Төвшрүүлэх сумын багийн иргэдийн Нийтийн хурлын дарга, багийн Засаг дарга, багийн эмч нарт нийт 118 мотоциклийг хүлээлгэн өгсөн байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлт

Улсын төсөвт 106490.0 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 701195.5 мянган төгрөг төвлөрүүлэхээс улсын төсөвт 75670.1 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 412873.8 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Шинэ төрлийн коронавирус /COVID-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагад гаднаас нэвтрэх урсгалд хяналт тавьж утгах үйлчилгээнээс 450 татвар төлөгчдөд бүх төрлийн үйлчилгээг үзүүллээ.

Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн 4-р сарын тайлангийн ирцийг 99.2 хувьтай хангуулан, байцаагч нарт хуваарилагдсан 23 тайланг баталгаажууллаа.

Хөрөнгө оруулалт

2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 49.076.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 63 төсөл арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөн. Үүнээс оны эхний 5 сарын байдлаар 2.011.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4.133.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл арга хэмжээ хэрэгжинэ.

Үүнээс, авто замын сангийн хөрөнгөөр 435.0 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээнээс 9 сая төгрөгийн, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.565.3 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээ хэрэгжихээс 79.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 132.7 сая төгрөгийн 3, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 427.2 сая төгрөгийн зардлаар 13 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа

4-р сард улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 1.990,0 сая төгрөгийн өртөг бүхий 11 тендер шалгаруулалтыг зарлаж шалгаруулсан бол 5-р сард 1.436,5 сая төгрөгийн 13 тендер шалгаруулалтыг зарлаж, 4 тендерийн үнэлгээ хийгдэж байна.

Орон нутгийн өмчит 51 төсөвт байгууллагад 101.5 сая төг-ийн үндсэн хөрөнгө худалдан авах зөвшөөрлийг олгож, 1 төсөвт байгууллагад 19.8 сая төг-ийн үндсэн

хөрөнгийн бүртгэлд бүртгэх зөвшөөрлийг олгосон 4 байгууллагад 457 нэр төрлийн 192.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлах зөвшөөрөл олгосон.

Санхүүгийн хяналт

Аудит, хяналт шалгалтаар тогтоогдсон нөхөн төлбөрийн барагдуулалт, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлаар 10 байгууллага, албан тушаалтантай холбоотой 43.6 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр Архангай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд албанаас албан тушаалтан тус бүрт холбогдох нэхэмжлэл гаргасан. Энэ хүрээнд иргэний хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд албаны дарга, аудитор-улсын ахлах байцаагч нар прокурорын хамт оролцож, 5-р сарын 20-ны байдлаар шүүхээс 4 хэрэг шийдвэрлэгдэж, шүүхийн шийдвэрээр нөхөн төлөгдөхөөр болсон бөгөөд бусад хэргүүд шалгагдаж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Хууль, хяналт

5-р сард аймгийн хэмжээнд 19 удаагийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол тохиолдсоноос объектын гал түймэр 4, ой, хээрийн гал түймэр 10, мал, амьтны гоц халдварт өвчин 3, зам тээврийн ослын дуудлага 1, эрэн хайх аврах ажиллагааны дуудлага 1 удаа тус тус тохиолдож 3 гэр, 2489 га талбай шатаж төр, иргэдийн хувийн өмчид нийт 1 тэрбум гаруй төгрөгийн хохирол учирсан байна.

Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах аврах 51 дүгээр анги, Эрэн хайх аврах салбарын нийт алба хаагчид объектын гал түймэр 2, ой, хээрийн гал түймэр 9, зам тээврийн ослын дуудлаганд 1, мал амьтны гоц халдварт өвчний дуудлаганд 1 удаа тус тус ажиллаж 1 өвөл зуны сууц, ард иргэдийн 52.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймрийн аюулаас авран хамгаалсан байна.

“Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээ авах тухай” Улсын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 1/01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар албан даалгавар, 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А/203 дугаар захирамж, ой хээрийн түймэртэй тэмцэх урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх талаар аймгийн Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын орлогч даргын 2020 оны 4-р сарын 13-ны өдрийн 205 дугаар албан бичгийн дагуу 19 сумын Засаг даргад “Амны хаалтаа зүүцгээе” аянг 2020 оны 4-р сарын 13-ны өдрөөс 5-р сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд сум, орон нутагтаа зохион байгуулахыг үүрэг болгож, 21 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж байна.

Иргэдийн эрүүл ахуйн хэв маяг, ухамсар соёлыг сайжруулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлж ЭМГ, МХГ, ОБГ, ЦГ-ын нийт 25 алба хаагч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтан, алба хаагч, иргэд нийт 25.400 хүнд шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг хүргэсэн.

Орон нутгийн “АВ”, “Тамир” 2 телевиз, зах худалдааны төвийн 2 узель, Онцгой байдлын газрын 1 чанга яригч, чанга яригчтай тусгай зориулалтын автомашинаар өдөрт 4 удаа ухуулга сурталчилгаа хийж иргэдэд зарлан мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байна.

Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн дагуу аймгийн боловсролын байгууллагуудын барилга байгууламжуудад гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт шалгалтыг 2020 оны 5-р сарын 01-нээс 20-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Шалгалтанд ерөнхий боловсролын сургууль-5, цэцэрлэг-12, дотуур байрны-2, нийт 19 объект хамрагдаж Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 128 зөрчил илрүүлж, 15 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан бусад

зөрчлүүдийг арилгуулахаар гал түймрийн болон гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх 6 албан шаардлага, 8 мэдэгдлийг тус тус шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ой, хээрийн түймэр гарах эрсдэл бүхий Булган, Төвшрүүлэх, Цэнхэр сумдад Улсын Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр албан даалгавар, 2020 оны А/203 дугаар захирамж холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний бэлэн байдал, ой хээрийн түймэр унтраах багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэлт, ногоон бүсэд зорчих байнгын болон хөдөлгөөнт хяналтын цэгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 159 зөрчил илрүүлж, 28 зөрчлийг газар дээр нь арилгуулж, заавар зөвлөмж өгсөн.

2020 оны 4-р сард аймгийн хэмжээнд 150 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг-34, хулгайлах гэмт хэрэг-76, малын хулгайн гэмт хэрэг-50, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг-5, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 28 байна.

Нийт 8578 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 8280 иргэнд 277 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 603.3 сая төгрөг, нөхөн төлүүлэлтийн хувь 38.1, нийт гэмт хэргийн илрүүлэлт 35.6 хувьтай байна.

Шүүхийн шинжилгээний алба 5-р сард криминалистикийн шинжилгээ 9, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 85, шүүх эмнэлгийн шинжилгээ 89, тусгай шинжилгээ 41-г тус тус хийсэн байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 5-р сард 2157137.4 төгрөгийн мөнгөн дүн бүхий 419 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 34.8, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 33.4 байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 3 суманд 21 хяналтын чиглэлээр 29 объектыг шалгалтанд, 17 объектыг зөвлөн туслах үйлчилгээнд, 11 объектыг урьдчилан сэргийлэх шалгалтанд тус тус хамруулж 16 албан шаардлага, 16 зөвлөмжөөр хугацаатай үүрэг даалгавар өгч 3 иргэнд 300000 төгрөгний торгууль ноогдууллаа.

Эрүүл мэндийн даатгалын сан болон сангаас санхүүжиж буй эрүүл мэндийн байгууллагуудад урьдчилан сэргийлэх шалгалт үргэлжилж байна.

Малын халдварт Шүлхий өвчний шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан Хайрхан суманд “Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хууль”-д заасан малын гоц халдварт, халдварт өвчинтэй тэмцэхэд хэрэгжүүлэх арга хэмжээний заалтуудын дагуу төлөвлөгөөт бус шалгалтыг хийлээ.

Хайрхан суманд мал амьтны гоц халдварт шүлхий өвчний сэжиг илэрсэнтэй холбогдуулан хил залгаа Цэцэрлэг сумын 14030 бод, 152964 бог малыг мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын байдалд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллалаа.

Ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд пестицидийн үлдэгдэл тодорхойлох хяналт шинжилгээгээр 15 иргэний импортоор орж ирж худалдаалагдаж байгаа 8 нэр төрлийн 54 бүтээгдэхүүнээс дээж авч лабораторийн шинжилгээнд хамрууллаа.

Стандарт хэмжил зүйн хэлтэс аймгийн Чанарын дэд хөтөлбөрийн хүрээнд 40.0 сая төгрөгийн өртөг бүхий хэмжих хэрэгсэл баталгаажуулах Цусны даралтын эталон, Газын колонк эталон, Шалгалт тохируулгын эталон, Эталон манометр EM40, Эталон жин ESB 5300, Эталон туухай OILMF1 зэрэг 7 төрлийн эталон тоног төхөөрөмжөөр тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн байна.

Хангай, Чулуут, Өндөр-Улаан, Тариат, Цахир сумдын 69 жижиглэн худалдаа эрхлэгч болон 14 хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрыг магадлах хяналтад хамрууллаа.

12 сумын 20 худалдаа үйлчилгээний газрын тохирлын гэрчилгээ сунгуулах болон шинээр авах хүсэлтийг хүлээн авч тохирлын үнэлгээ хийж гэрчилгээ олгоод байна.

Улс болон олон улсын стандартаар иргэн аж ахуй нэгжийг хангах чиглэлээр 3 иргэн 3 аж ахуй нэгжид 19 төрлийн 191360 төгрөгний стандартаар үйлчилж, 19 сумын 52 шатахуун түгээх станцын 107 ш шатахуун түгээгүүр /182 ш хошуу/-ийг, мөн 2ш

дугаар бүртгэлтэй байгаа тохиолдолд тухайн дугаар руу жилийн турш сар бүр идэвхжих 10 GB датаны эрх олголоо. Олгосон шинэ дугааруудыг жилийн турш сар бүр 10 GB датагаар цэнэглэнэ. Энэхүү арга хэмжээнд Архангай аймгийн ЕБС-ийн 2000 гаруй сурагчид хамрагдав.

Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэгчдэд зориулан Элсэлтийн ерөнхий шалгалтын урьдчилсан сорилгыг Google forms програм ашиглан онлайнаар зохион байгуулав. Уг шалгалтад давхардсан тоогоор 1355 сурагч хамрагдсан.

“Заавар батлах тухай” БСШУС-ын сайдын 2020 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/220 дугаар тушаалын дагуу элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэгчдийг ерөнхий боловсролын сургууль дээр байнгын шуурхай жижүүр ажиллаж, ЕБС-ийн багш, сурагчид хөл хорионы болон халдвар хамгааллын дэглэмийг баримтлан танхимын сургалтад хамруулж байна.

Соёл, урлаг

Хорио цээрийн дэглэм тогтоож, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, үзвэр үйлчилгээг зохион байгуулахыг хориглосонтой холбогдуулан аймгийн Нийтийн номын сан, Хөгжимт драмын театр, Музей иргэд олон нийтэд чиглэсэн урлаг, соёлын үйлчилгээг цахимаар болон зайнаас зохион байгуулж байна. Тухайлбал:

Нийтийн номын сан үндсэн фонд, нийтийн болон хүүхдийн уншлагын танхимаар нийт 14 уншигч шинээр бүртгэж, 109 ирэгсэдэд 250 ширхэг сонин 214 номыг олгож, зөөврийн номын сангийн үйлчилгээгээр төрийн 14 байгууллагын 105 ирэгсэдэд 310 номоор, явуулын номын сангийн үйлчилгээгээр зорилтот бүлгийн 15 өрхөд 30 ширхэг номоор тус тус үйлчилсэн.

Мөн тус номын сангаас үндсэн фондын 247 ширхэг номыг номын сан-номзүйн ангиллаар ангилах, утга зохиол, аман зохиол, биеийн тамир-спортын шинжлэх ухааны салбарын 1505 ширхэг номыг хуучин данстай тулган, номын нэг бүрчилсэн бүртгэлд стандартын дагуу шинэчилэн хуулах, номын сангийн MonKoha үүлэн технологийн программд ном шивэх ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд 1000 нэрийн 4601 номыг шивж, бар коджуулан шинжлэх ухааны салбараар системчилэн байрлуулах, уншигчдын эрэлт хэрэгцээ хангахгүй болсон урагдаж, гэмтсэн 283 ширхэг номыг сэлбэн засах, үндсэн фондын 1505 ном, хүүхдийн уншлагын танхимын 4200 номын бар кодыг нааж, тоосыг арчин, шинжлэх ухааны салбараар байршуулах ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Аймгийн Музей “Заяын хүрээний үүсэл хөгжил”, Зая гэгээн Жамбацэрэнгийн хэрэглэж байсан “Таван саваагүй”, “Хэт хутга”, “Толгойн боолт”, “Хаш таваг”, “Шанаган хуур”, “Домбо”, “Дэвэр” зэрэг 8 ширхэг үзмэрийн мэдээллийг байгууллагын фэйсбүүк хуудас болон “Монцамэ агентлаг”, “Архангай амьдрал сонин”, “Архангай сэтгүүл” зэрэг мэдээллийн эх үүсвэрээр дамжуулан олон нийтэд хүргэж байна.

Аймгийн тахилга шүтлэгтэй газар нутгийг бүртгэн баримтжуулах ажлыг 2020 оны 03-р сарын 01-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байгаа бөгөөд 5-р сарын 20-ны байдлаар 5 сумын 78 ш газар нутгийг бүртгэн баримтжуулсан бөгөөд цахим бүртгэлийн программд 57 ш газар нутгийг бүртгэн баримтжуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.3-т тусгагдсаны дагуу Булган уулын зургийг шинэчлэн зуруулах ажилд шаардагдах төсвийг батлуулан, тухайн ажлыг хийж гүйцэтгэх талтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан тус ажлыг 5-р сард хийж гүйцэтгүүлэн хүлээн авлаа.

Хөгжимт драмын театр орон нутгийн “АВ” телевизтэй хамтран хүүхдийн шинэ бүтээл болох “Амьдрал тэтгэгч” хүүхдийн жүжгийг дэлгэцийн бүтээл болгож 4-р сарын 28-аас 5-р сарын 15-ны өдрийг хүртэл 8 удаа, 5-р сарын 03-наас 15-ны хооронд “Эрдэнийн хэлхээ” уран бүтээлийн тоглолтыг дэлгэцийн бүтээл болгож “АВ” телевизээр 7 удаагийн цацалтаар тус тус үзэгчдийн хүртэл болгосон байна.

Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газраас аймгийн төвийн олон нийтийн үйлчилгээний газар, гудамж талбайгаар явж амны хаалт зүүсэн байдалд үнэлгээ хийхэд иргэдийн 70 орчим хувь нь

амны хаалт зүүсэн байсбн бөгөөд амны хаалт зүүгээгүй 200 орчим иргэнд амны хаалт зүүх зөвлөмж өгч, амны хаалтны хэрэглээний асуумж авлаа.

Асуумжаар иргэд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэхийн тулд амны хаалт зүүх шаардлагатай гэдгийг 100 хувь мэдэж байгаа бөгөөд олон нийтийн телевиз, интернет, гар утасны мессеж, олон нийтийн газар байршуулсан зурагт хуудас, эрүүл мэндийн байгууллагуудын ажилчдаас амны хаалт зүүх талаар зөвлөгөө, мэдээлэл авсан байна.

Орчны эрүүл мэнд, жорлон, угаадасны нүхний халдваргүйжүүлэлтийн талаар иргэдэд зориулсан зөвлөмж боловсруулж, аймгийн төвийн 105 албан байгууллага, аж ахуйн нэгжид мөн бүх сумын Засаг дарга нар, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлэн, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 6609 айл өрхөд хүргүүлж, 3564 айл өрх нүхэн жорлон, угаадасны нүхээ зөвлөмжийн дагуу халдваргүйжүүлсэн.

Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг суманд зохион байгуулах үеэр коронавируст халдварын болзошгүй эрсдэлтээс урьдчилан сэргийлэх халдварын хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг боловсруулж, Автотээврийн төв болон сумын эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн.

Улаанбаатараас Архангай аймгийн Эрдэнэбулган, Чулуут, Тариат, Цахир, Ихтамир сумын чиглэлийн хот хоорондын зорчигч тээврийн 106 автобусны 2297 зорчигчийн биеийн халууныг үзэж, тандалт хийсэн. Биеийн халуун нэмэгдсэн хүн байхгүй байна.

“Ажлын байранд коронавируст халдварын сэжигтэй тохиолдлын үед авах арга хэмжээний зөвлөмж”-ийг аймгийн төвийн 105 байгууллага, аж ахуйн нэгж, бүх сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, мэргэжилтнүүдэд “Коронавируст халдварын үед голомтын халдваргүйжүүлэлт хийх” сэдвээр 2 цагийн цахим сургалтыг зохион байгуулж, 210 эмч, ажилчид хамрагдсан.

Хашаат, Хотонт сумын ЭМТ-ийн эмч, багийн эмч, эх баригч, сувилагч нарт “Өсвөр үеийнхэнд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын үзүүлэх тусламж үйлчилгээ” сургалтыг зохион байгуулж, 42 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2020 оны 5-р сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 886 иргэн бүртгэлтэй байгаагаас 453 эмэгтэй. Шинэ ажлын байр 133 үүнээс байнгын ажлын байр 96, улирлын ажлын байр 3, түр ажлын байр 34 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 117, зуучлал 106 байна. Тухайн сарын 18-ны байдлаар 63 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 8, бага- 26, суурь-134, бүрэн дунд- 539, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 22, тусгай мэргэжлийн дунд-16, Дипломын бакалаврын-141 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 31 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч НДХэлтэс рүү хүргүүлсэн. Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн болон нөхөрлөл хоршооны ажлын байрыг дэмжих зорилгоор хувиараа хөдөлмөр эрхлэгч 34 иргэнд 146.0 сая.төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг олгож, 34 ажлын байр шинээр бий болсон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хувиараа хөдөлмөр эрхлэгч 16 иргэнд 64.0 сая.төгрөгийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгож, хөгжлийн бэрхшээлтэй 16 иргэн ажлын байртай болсон байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч 16 ахмад настанд 24 сарын хугацаатай 100 хувийн эргэн төлөгдөх 27.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож, 16 ахмад настан хувиараа хөдөлмөр эрхэлж байна.

Нийтийг хамарсан ажилд ажилгүй 77 иргэнийг хамруулж 11.2 сая.төгрөгийн цалин хөлсийг олгож, түр ажлын байраар хангасан байна.

Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 32 иргэн, аж ахуйн нэгжид 281.0 сая төгрөгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг олгож, 82 ажлын байр бий болсон байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг "сэргээн засах" чиглэлээр гэрээлэн гүйцэтгэхээр магадлан итгэмжлэгдсэн "Очцо" эрүүл мэндийн төв", "Хангай манба дацан" зэрэг аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх /эцэг/ зэрэг зорилтот бүлгийн 43 иргэнд үйлчилгээг хүргэж байна.

Нийгмийн даатгалын санд 2020 оны 5-р сарын 28-ны байдлаар нийт 6.7 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 117.6 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 14.8 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 21.8 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 3020.3 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлсэн.

Нийгмийн даатгалын санд 2019 онд 6,7 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 тэрбум төгрөгөөр буурсан.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд

- Тэтгэврийн даатгалын санд 65,3 % буюу 4430,3 сая төгрөг
- Тэтгэмжийн даатгалын санд 7,4 % буюу 499 сая төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 5,6 % буюу 377,2 сая төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 1,6 % буюу 110,2 сая төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын санд 20,1 % буюу 1363,7 сая төгрөг

Гэр бүл, хүүхэд, залуучууд

Хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсч хөгжсөний 95 жилийн ойн өдрийг 5-р сарын 08-ны өдөр тэмдэглэж, энэ хүрээнд хүүхдийн байгууллагын түүхийн сургалт мэдээллийг цахим орчинд хийж, 3 ахмад ажилтны дурсамж-ярилцлага зэрэг 13 удаагийн мэдээ, мэдээлэл бэлтгэж, олон нийтэд түгээсэн бөгөөд нийтдээ 5712 хүнд хүрсэн байна.

Олон улсын гэр бүлийн өдрийг тэмдэглэж, Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг Орда, Хангайн хүнс, Сайхан талх, Гост үйлдвэр зэрэг 4 байгууллагатай зөвшилцөн хэрчсэн гурил, гурилан бүтээгдэхүүн, талх зэрэг 16 нэр төрлийн 1500 бүтээгдэхүүнд "Гэр бүл хайрын нэгдэл" гэр бүлдээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны уриалгын хэвлэмэл материалыг байрлуулан 1500 хүнд түгээсэн. Мөн "Гэр бүл хайрын нэгдэл", "Гэр бүлийн үнэ цэнэ", "Олон улсын гэр бүлийн өдөр" сэдвүүдийн хүрээнд видео зөвлөгөө бэлтгэн байгууллагын фэйж хуудас болон орон нутгийн цахим хуудсуудад байршуулан нийт 3450 хүний хандалт авсан байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Архангай аймгийн хэмжээнд 2020 онд 2.053.2 мянган толгой хээлтэгч мал төллөхөөс 5-р сарын 20-ны байдлаар 1774885 мянган толгой мал төллөсөн байна.

Үүнд ингэ 208 буюу 69.7 хувь, гүү 42458 буюу 43.9 хувь, үнээ 132704 буюу 77.3 хувь, эм хонь 1127444 буюу 94.1 хувь, эм ямаа 472071 буюу 79.7 хувь төллөж, аймгийн дүнгээр бод малын 65.3 хувь, бог малын 89.7 хувь төллөж, 1394202 мянган толгой төл 85.1 хувьтай бойжин, мал төллөлт 86.4 хувьтай байна.

Том малын зүй бус хорогдлоор 283.2 мянган толгой мал хорогдож нийт малын 4.5 хувийг эзэлж байна.

Газар тариалан

Архангай аймаг энэ хавар үр тариа 10000 га, тэжээлийн таримал 1500 га, тосны таримал 1000 га, төмс 280 га, хүнсний ногоо 140 га-д нийт 12920 га талбайд тариалалт хийнэ.

Энэ оны тариалалт 5-р сарын 4-нөөс эхэлсэн бөгөөд 5-р сарын 20-ны байдлаар өмнө жилийн уриншид Төвшрүүлэх сум 2020 га, Хотонт сум 580 га, Өлзийт сум 240 га, нийт 2840 га талбайд улаан буудай тариалж 28 хувьтай байна.

Төмс, хүнсний ногоо тариалагчдын хувьд Өгийнуур, Цэнхэр, Эрдэнэбулган, Булган, Чулуут, Ихтамир, Жаргалант, Батцэнгэл зэрэг сумууд тариалалтаа эхэлсэн бөгөөд нийт

53,9 га талбайд төмс тариалж 20,4 хувь, 36 га талбайд хүнсний ногоо тариалж 26 хувьтай байна.

Хөдөө аж ахуйг дэмжих сангаас авсан нийт 1897560.0 мянган төгрөгийн үнэтэй 361 ширхэг бага оврын тракторын зээлээс 782322477 төгрөгийн урьдчилгаа төлж, 140950.0 төгрөгийг хугацаандаа төлж, 974287.523 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт 100775 ширхэг жимсний суулгацын 238841.45 мянган төгрөгийн дүнгээс 17403.875 мянган төгрөг хугацаандаа төлж, 191792.375 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй, 29645.2 мянган төгрөгийн зээлийг шинээр олгосон байна.

Трактор-4, үрлэгч-1, хаман боогч-3, хадуур-2, анжис-1, тармуур-2, чиргүүл-1 ширхэг захиалга ирүүлснийг Хөдөө аж ахуйг дэмжих санд уламжлав.

Буудай тариалсан 6 сумын иргэн, аж ахуй нэгжийн талбайд очиж, тариалалтын технологи, арга зүйн зөвлөгөө өгөв.

Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж буй томоохон худалдааны төв болох “Гост Трейд” ХХК, “Тансаг Трейд” ХХК, “Тансаг Оюу” ХХК, “Ижий Трейд” ХХК, “Жи Эи Би” ХХК, “Хадат Хужирт” ХХК, “Бүрэн Ар” ХХК-иудад хүнсний нөөцийн судалгааг 7 хоног бүр ирүүлэх тоот хүргүүлж, судалгааг нэгтгэн, ХХААХҮЯ-ны ХҮХБЗГ болон аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлсэн. Судалгаагаар мах 45.4 тн буюу 4 хоног, гурил 258 тн буюу 34 хоног, гоймон 22.8 тн буюу 2 хоног, будаа 72.1 тн буюу 19 хоног, сахар 48.4 тн буюу 19 хоног, ургамлын тос 21.2 тн буюу 12 хоног, давс 26.3 тн буюу 66 хоног, төмс 41.2 тн буюу 15 хоног, хүнсний ногоо 20.3тн буюу 2 хоног, ундны ус 32.7 мян.л буюу 1 хоногийн нөөцтэй байна

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин, аялал жуулчлал

Цахир, Хангай, Тариат, Чулуут, Өндөр–Улаан, Жаргалант, Ихтамир, Булган сумдад хийгдэх Аялал жуулчлалын сурталчилгааны самбарын тендерийг БОАЖЯ /202002051/01/01 дугаар бүхий урилгаар зарлаж, “Гео мастер” ХХК шалгаран, гэрээ байгуулсан байна.

Шилмүүст болон навчит модны тарьц, суулгацыг бий болгох зорилгоор 3 га мод үржүүлгийн газрын 20Х6, 18Х6, 12Х4, 6Х4, харьцаатай гурван хүлэмжинд хөрс боловсруулалтын ажлыг технологийн дагуу хийж 15 кг шинэс, шар хуайс, агч, гүйлс, бүйлс зэрэг мод, сөөгийн үр, бургас, улиасны 1000 гаруй мөчир тарьж усалгаа, арчилгааны ажлыг хийж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр ойжуулалтын ажлыг 30 га талбайд Цэнхэр сумын Цэнхэр багийн Нарийн давааны ард “Ойд хангай” ХХК-иар гүйцэтгүүлж ажлын гүйцэтгэлд хяналт тавьж заавар зөвлөмж өгч ажиллаж байна.

Сум дундын ойн анги 5-р сарын 2-ноос 14-ний хооронд Эрдэнэмандал, Ихтамир, Цэнхэр суман дахь мод үржүүлгийн газрын хаврын тариалалтаар 3 кг шинэс, 3 кг шар хуайс, 2000 ш улиас модны мөчир, 1кг гүйлс голт борын үрийг тарьсан байна. Мөн Цэнхэр суманд 20х6 м харьцаатай хүлэмж барьж тариалалт хийсэн байна.

Аймгийн Онцгой байдлын газар Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дэргэдэх Цаг агаарт зориудаар нөлөөлөх “Цэцэрлэг бороо-1” экспедицтэй хамтран 5-р сард 3 удаа цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явууллаа.

Үйлдвэрлэл үйлчилгээ

Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 4-р сарын 17-ны өдрийн А/131 дүгээр тушаалаар “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ыг баталж зээлийг хүртээмжтэй байлгах үүднээс сангаас шууд олгох зээлийн хэмжээг орон нутагт 20.0-200.0 сая төгрөг хүртэл байхаар шийдвэрлэсэн.

Аймгийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд санд 2020 оны 4-р сарын 20-ны өдрөөс 5-р сарын 19-ний өдөр хүртэл 32 аж ахуйн нэгжийн 3.972.661.800 төгрөгийн санхүүжилт хүссэн төслийг битүүмжлэн хүлээн авч цахим бүртгэлийн системд бүртгэсэн.

Сум хөгжүүлэх сангийн 2019 оны жилийн эцсийн зээлийн чанарын үзүүлэлт болон зээлийн ангиллын мэдээг 5-р сарын 01-ний өдрийн байдлаар нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Зээлийн чанарын ангиллын хувьд, хэвийн зээл 700 иргэн, аж ахуйн нэгжид 2.774.992.913 төгрөг, анхаарал хандуулах зээл 272 иргэн, аж ахуйн нэгжид 923.874.244 төгрөг, хэвийн бус 91-180 хоногтой зээл 161 иргэн, аж ахуйн нэгжид 395.477.997 төгрөг, эргэлзээтэй 181 хоногтой зээл 128 иргэн, аж ахуйн нэгжид 446.218.695 төгрөг, муу 361 хоногтой зээл 632 иргэн, аж ахуйн нэгжид 2.267.842.632 төгрөг, аймгийн хэмжээнд нийт 1689 иргэн, аж ахуйн нэгжид 6.446.735.391 төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Архангай аймгийн хэмжээнд нийт 408 худалдаа үйлчилгээний төв байгаагаас томоохон худалдааны төв 4, их дэлгүүр 1, супермаркет 41, минимаркет 24, хүнсний дэлгүүр 325, цахим худалдаа 13 байна.

Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах тусгай зөвшөөрлийг 2019 онд нийт 164-г олгосон бол 2020-оны эхний 5 сарын байдлаар 9-ийг тусгай зөвшөөрлийг олгосон байна.

Барилга, дэд бүтэц

2019 оны улсын төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй Архангай аймгийн Батцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын барилга угсралт, Хангай сумын Эрүүл мэндийн төвийн халаалтын тогооны засвар, Хангай сумын Гичгэнэ багийн төвийн барилга угсралтын ажлуудыг ашиглалтанд оруулах комисс ажиллуулж байнгын ашиглалтанд хүлээн авсан.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга угсралт, Хангай сумын сургуулийн дотуур байрны засвар, Өлзийт сумын сургуулийн өргөтгөлийн барилга угсралт, Хайрхан сумын 320 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажлуудын гэрээ байгуулагдсан байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 4-р сарын 21-ний өдрийн А/241 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж 2020 оны 4-р сарын 25-ны өдрөөс 5-р сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд Хаягжуулалтын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, 2019 онд хийгдсэн хаягийн мэдээллийн санг газрын кадастрын мэдээллийн сантай тулгаж шалган засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл бүхий жагсаалт гаргах ажлыг хийж гүйцэтгэн хаягийн мэдээллийн санг сум тус бүрээр SHP өргөтгөлтэй файлаар ГЗБГЗЗГ-т хүргүүллээ.

-----oOo-----